

**МОНГОЛБАНКНЫ ЕРӨНХИЙЛӨГЧ, САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ  
ХОРООНЫ ДАРГА,  
САНГИЙН САЙДЫН ХАМТАРСАН ТУШААЛ**

2010 оны 7 сарын 20-ны өдөр

Дугаар 434/113/167

Улаанбаатар хот

Төв банк /Монголбанк/-ны тухай хуулийн 27<sup>2</sup> дугаар зүйлийн 4 дэх хэсгийг үндэслэн  
ТУШААХ НЬ:

1. “Банкны Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүдийг нэр дэвшүүлэх, томилох, чөлөөлөх журам”-ыг хавсралт ёсоор баталсугай.
2. Энэ тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Монголбанкны Тэргүүн дэд ерөнхийлөгч /Б.Жавхлан/, Сангийн дэд сайд /Т.Очирхүү/, Санхүүгийн зохицуулах хорооны дэд дарга /Б.Шаравсамбуу/-т тус тус үүрэг болгосугай.
3. Энэ журмыг 2010 оны 7 дугаар сарын 20-ны өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

**МОНГОЛБАНКНЫ  
ЕРӨНХИЙЛӨГЧ**

**САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ  
ХОРООНЫ ДАРГА**

**САНГИЙН САЙД**

**Л.ПҮРЭВДОРЖ**

**Д.БАЯРСАЙХАН**

**С.БАЯРЦОГТ**

## **БАНКНЫ ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХАРААТ БУС ГИШҮҮДИЙГ НЭР ДЭВШҮҮЛЭХ, ТОМИЛОХ, ЧӨЛӨӨЛӨХ ЖУРАМ**

### **НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ**

- 1.1 Энэ журмын зорилго нь банкны ТУЗ-ын хараат бус гишүүд /цаашид хараат бус гишүүн гэнэ/- ийг нэр дэвшүүлэх, томилох, чөлөөлөх харилцааг зохицуулахад оршино.
- 1.2 Банк хараат бус гишүүдийг нэр дэвшүүлэх, томилох болон чөлөөлөхдөө Компанийн тухай хууль, Банкны тухай хууль, бусад холбогдох хууль тогтоомж болон энэ журамд нийцүүлнэ.
- 1.3 ~~Хувьцаат компанийн хэлбэрээр байгуулагдсан банкны төлөөлөн удирдах зөвлөл гурав ба түүнээс дээш, хязгаарлагдмал хариуцлагатай компанийн хэлбэрээр байгуулагдсан банкны төлөөлөн удирдах зөвлөл нэг ба түүнээс дээш хараат бус гишүүнтэй байна.~~  
**Хувьцаат компанийн хэлбэрээр байгуулагдсан банкны төлөөлөн удирдах зөвлөл гурав ба түүнээс дээш, хязгаарлагдмал хариуцлагатай компанийн хэлбэрээр байгуулагдсан банкны төлөөлөн удирдах зөвлөл нь нэг ба түүнээс дээш хараат бус гишүүнтэй байна. Системийн нөлөө бүхий банк компанийн хэлбэрээс үл хамааран төлөөлөн удирдах зөвлөл гурав ба түүнээс дээш хараат бус гишүүнтэй байна.**

*МБЕ-ийн 2015 оны 2 сарын 24-ний өдрийн А-42/34/49 дүгээр хамтарсан тушаалаар өөрчлөв.*

### **ХОЁР. ХАРААТ БУС ГИШҮҮН, ТҮҮНИЙ ЭРХ ҮҮРЭГ**

- 2.1 Хараат бус гишүүн нь Банкны тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1, 33 дугаар зүйлийн 33.3 дахь хэсэгт заасан шалгуурыг хангасан иргэн байна.
- 2.2 Хараат бус гишүүн нь ТУЗ-ын харьяа Аудитын болон Эрсдэлийн удирдлагын хороонд ажиллаж, Компанийн тухай хуульд заасан сонирхлын зөрчилтэй хэлцлийг батлахад заавал оролцож санал өгнө.
- 2.3 Хараат бус гишүүн нь Банкны тухай хуулийн 31 дүгээр зүйлд заагдсан үйл ажиллагааг төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн хамт хийж гүйцэтгэнэ.
- 2.4 Шаардлагатай тохиолдолд хувьцаа эзэмшигчдэд хандан бүх гишүүдийн хурлыг зарлуулан хуралдуулж болно.
- 2.5 Монголбанкинд хүсэлт гарган банкинд шалгалт явуулж болно.
- 2.6 Ажлаа бүх гишүүдийн хуралд жилд нэгээс доошгүй удаа тайлагнана.

### **ГУРАВ. ХАРААТ БУС ГИШҮҮНД НЭР ДЭВШҮҮЛЭХ**

- 3.1. Хараат бус гишүүнд нэр дэвшигчдийг дараах хоёр аргаар нэр дэвшүүлнэ:
  - 3.1.1 Банкны хувь нийлүүлэгчдийн хурлаас;
  - 3.1.2 Олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр зарлан.
- 3.2 Нэр дэвшигчийг дараах нөхцөлд энэ журмын 3.1.1-д заасны дагуу дэвшүүлнэ:
  - 3.2.1 Банк 3 ба 3-аас доошгүй тооны нөлөө бүхий бус хувьцаа эзэмшигчтэй бол Банкны тухай хууль болон энэ журмын дагуу шаардлага хангасан иргэний нэр дэвшүүлж болно;
  - 3.2.2 Банк нь хувьцаат компани бол;

3.3 Хараат бус гишүүнд энэ журмын 3.1.1-д заасны дагуу нэр дэвшүүлэх тохиолдолд хувьцаа эзэмшигч нь хувьцааны дүнгээс үл хамааран саналын нэг эрхтэйгээр хувь нийлүүлэгчдийн хуралд оролцож, олонхийн саналаар шийдвэр хүчин төгөлдөр болно.

3.4 Нэр дэвшигчийг дараах нөхцөлд энэ журмын 3.1.2-д заасны дагуу дэвшүүлнэ:

3.4.1 Нөлөө бүхий бус хувьцаа эзэмшигчид хараат бус гишүүнд нэр дэвшүүлээгүй;

3.4.2 Хувь нийлүүлэгчдийн хурлаас хараат бус гишүүнд нэр дэвшигч тодроогүй;

3.4.3 Хараат бус гишүүнд нэр дэвшигч холбогдох хууль, энэ журмаар тавьсан шаардлагыг хангаагүй.

3.5 Хараат бус гишүүнд нэр дэвшигчдийг олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр зарлан дэвшүүлэх бол дараах зарчмыг баримтлана:

3.5.1 Өдөр тутмын 3-аас доошгүй хэвлэлд, 2 хоногоос ихгүй давтамжтай, 2-3 удаа зарлана;

3.5.2 Зарлахдаа хараат бус гишүүнд тавигдаж буй шаардлага, бүрдүүлэх баримт материалыг тодорхой заасан байна;

## ДӨРӨВ. СОНГОН ШАЛГАРУУЛАХ ХОРОО

4.1 Сонгон шалгаруулах хороо нь хараат бус гишүүнд нэр дэвшигчдийг тодруулах, хүсэлт гаргагчийн бүрдүүлсэн материалыг хүлээж авах, хянах, сонгох, томилуулах үүрэг бүхий түр хороо байна.

4.2 Хувь нийлүүлэгчдийн хурлаас 4-өөс доошгүй гишүүний бүрэлдэхүүнтэй Сонгон шалгаруулах хороог байгуулна. Сонгон шалгаруулах хорооны гишүүдийн тоог хувь нийлүүлэгчдийн хурлын дарга нээлттэй, санал хурааж тогтооно.

4.3 Сонгон шалгаруулах хорооны нийт гишүүдийн 75-аас доошгүй хувь нь банкны нөлөө бүхий бус хувьцаа эзэмшигчдээс бүрдсэн байна.

4.4 Сонгон шалгаруулах хорооны гишүүн болох саналтай хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалтыг хувьцаа эзэмшигчдээс нээлттэй тодруулна.

4.5 Нэрсийн жагсаалтын дагуу санал хураалт явуулж, хамгийн олон санал авсан хувьцаа эзэмшигчийг Сонгон шалгаруулах хорооны гишүүнээр сонгоно.

## ТАВ. ХАРААТ БУС ГИШҮҮНИЙГ СОНГОХ

5.1 Хэвлэл мэдээллийн хэрэгслээр сүүлийн зар тараагдсанаас хойш 14 хоногийг хугацаанд хараат бус гишүүнд нэр дэвшигчдийн хүсэлтийг Сонгон шалгаруулах хороо бүрдүүлсэн материалын хамт нэр дэвшигчийг байлцуулан протокол үйлдэн хүлээн авна.

5.2 Хараат бус гишүүнд нэр дэвшигчдийн материалыг хүлээн авсанаас хойш 7 хоногийг дотор ТУЗ Сонгон шалгаруулах хороог хуралдуулах тухай зарыг хорооны гишүүдэд тараана.

5.3 Сонгон шалгаруулах хорооны хурал зар тарааснаас хойш 3-7 хоногийн дотор хуралдсан байна.

5.4 Хараат бус гишүүнийг хоёр жилийн хугацаатай сонгоно.

5.5 Хараат бус гишүүний хугацаа дуусгавар болсон бол хараат бус гишүүний сонгон шалгаруулалтыг Банкны тухай хууль болон энэ журмын дагуу явуулна.

5.6 Хараат бус гишүүн улиран сонгогдож болно.

5.7.Хараат бус гишүүн нь компанийн зохистой засаглалын чиглэлээр сургалтад заавал хамрагдсан байна.

5.8.Сонгон шалгаруулах хороо хуралдаж олонхийн саналаар хараат бус гишүүнийг сонгоно.

5.9. Хараат бус гишүүнийг сонгосоноос хойш ажлын 5 хоногийн дотор хараат бус гишүүний дэлгэрэнгүй мэдээллийг энэ журмын хавсралт 1-ийн дагуу бэлтгэж Монголбанкинд хүргүүлнэ.

5.10.Мэдээллийг Монголбанкнаас 14 хоногийн дотор хянаж үзээд хариу зөвшөөрөл өгнө. Нэг болон түүнээс дээш шаардлага хангасан хүн байгаа тохиолдолд тэдгээрийн аль нэгийг томилох зөвшөөрлийг банкинд өгж болно.

5.11.Шаардлага хангаагүй тохиолдолд дахин сонгон шалгаруулалт хийх хугацаатай үүргийн ТУЗ буюу Сонгон шалгаруулах хороонд өгнө.

~~5.12.Нэрсийн жагсаалтаас шаардлага хангасан болон Монголбанкнаас зөвшөөрсөн нэр дэвшигчийг Сонгон шалгаруулах хорооноос ТУЗ-ын хуралд оруулж хэлэлцүүлэн батлуулна.~~

**Нэрсийн жагсаалтаас шаардлага хангасан болон Монголбанкнаас зөвшөөрсөн нэр дэвшигчийг Сонгон шалгаруулах хорооноос Хувьцаа эзэмшигчдийн хуралд оруулж хэлэлцүүлэн батлуулна.**

[МБЕ-ийн 2015 оны 2 сарын 24-ний өдрийн А-42/34/49 дүгээр хамтарсан тушаалаар өөрчлөв.](#)

## ЗУРГАА. ХАРААТ БУС ГИШҮҮНЭЭС ЧӨЛӨӨЛӨХ

~~6.1.Хараат бус гишүүний сонгуульт хугацаа дуусгавар болж, улиран сонгогдоогүй бол хараат бус гишүүнээс чөлөөлөгдөнө.~~

**Хараат бус гишүүний сонгуульт хугацаа дуусгавар болсон, улиран сонгогдоогүй болон 6.2 дахь заалтаас үл хамааран үүрэгт ажлаас нь чөлөөлөх тохиолдолд холбогдох үндэслэл, тайлбарыг Монголбанкинд ирүүлж, зөвшөөрөл авна.**

[МБЕ-ийн 2015 оны 2 сарын 24-ний өдрийн А-42/34/49 дүгээр хамтарсан тушаалаар өөрчлөв.](#)

6.2.Хараат бус гишүүний сонгуульт хугацаа доорх тохиолдолд хугацаанаас өмнө дуусгавар болно:

6.2.1 Гэмт хэрэг үйлдсэнийг нь шүүх тогтоосон;

6.2.2 Ажлаа бүх гишүүдийн хуралд тайлагнаагүй буюу үүрэгт ажлаа хангалтгүй биелүүлсэн;

6.2.3 Банкны болон Компанийн тухай хуулиар заасан шалгуурыг цаашид хангахаа больсон;

6.2.4 ТУЗ-ын хуралд хүндэтгэн үзэх шалтгаангүй жилд 2-оос дээш удаа оролцоогүй;

6.2.5 Ашиг сонирхолын зөрчил үүссэн;

6.2.6 Биеийн эрүүл мэндийн байдал болон хүндэтгэн үзэх бусад шалтгаанаар албан үүргээ цаашид гүйцэтгэх боломжгүй гэж үзэж, уг сонгуульт ажлаас чөлөөлж өгөх хүсэлт

гаргасан;

#### 6.2.7 Хуульд заасан бусад үндэслэлүүд

Банкны төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүдийг нэр дэвшүүлэх, томилох, чөлөөлөх журмын 1 дүгээр хавсралт

Банкны ТУЗ-ийн гишүүнд тавигдах шаардлага

Холбогдох зүйл, заалт: Банкны тухай хуулийн 32.1 дэх хэсэг

Д/д	Шаардлага	Бүрдүүлэх материал
1	Зээл, батлан даалт, баталгааны гэрээгээр хүлээсэн хугацаа хэтэрсэн аливаа өргүй	Монголбанкин дахь Зээлийн мэдээллийн сангийн лавлагаа
2	Төрийн эсрэг болон эдийн засгийн гэмт хэрэгт ял шийтгүүлж байгаагүй	ЦЕГ-ын лавлагаа
3	Ёс зүйн болон бизнесийн нэр хүнд нь банкиг удирдахад харшлахгүй байх	Монголбанкнаас зөвшөөрсөн албан бичиг
4	Санхүүгийн зах зээлд мэргэжлийн үйл ажиллагаа эрхэлдэг бусад байгууллагын эрх бүхий албан тушаалтан бус байх	Өөрөө биш болохоо баталсан бичиг
5	Зөрчлийн улмаас банк ба банк бус санхүүгийн байгууллагын тусгай зөвшөөрөл хүчингүй болох үед эрх бүхий албан тушаалтнаар ажиллаж байсан бол тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосноос хойш гурван жил өнгөрсөн байх	Монголбанк болон СЗХ-ны тодорхойлолт, мөн өөрөө баталсан бичиг
6	Санхүүгийн зах зээлд мэргэжлийн үйл ажиллагаа эрхэлдэг байгууллагад эрх бүхий албан тушаалтнаар ажиллаж байх үедээ захиргааны хариуцлага хүлээсэн бол үүнээс хойш гурван жил өнгөрсөн байх	Монголбанк болон СЗХ-ны тодорхойлолт, мөн өөрөө баталсан бичиг

Банкны ТУЗ-ийн хараат бус гишүүнд тавигдах шаардлага

Холбогдох зүйл, заалт: Банкны тухай хуулийн 33.3 дахь хэсэг

Д/д	Шаардлага	Бүрдүүлэх материал
1	Банкны ТУЗ-ийн гишүүнд тавигдах бүх шаардлага	Дээрхийг харна уу.
2	Банк, санхүү, эдийн засгийн дээд боловсролтой, мэргэжлээрээ наймаас доошгүй жил ажилласан, үүнээс дөрвөөс доошгүй жил нь банк, санхүүгийн байгууллагад эрх бүхий албан тушаал хашсан байх	Дээд боловсролын үнэмлэхийн хуулбар, ажиллаж байсан байгууллагын тодорхойлолт
3	Төрийн улс төрийн болон төрийн жинхэнэ албан тушаал хашдаггүй байх	Ажлын газрын тодорхойлолт, өөрөө биш болохоо баталсан бичиг
4	Эрх бүхий албан тушаалтнаар нь ажиллаж байсан хуулийн этгээд дампуурсан, төлбөрийн чадваргүй болсон нь тухайн этгээдээс аливаа хэлбэрээр шалтгаалаагүй нь нотлогдсон байх	Шүүхийн лавлагаа, СЗХ болон бусад байгууллагын тодорхойлолт
5	Банкны эрх бүхий албан тушаалтан, түүний холбогдох этгээд бус байх	Банкны албан бичиг

6	Банкны нөлөө бүхий хувьцаа эзэмшигч бус байх, эсхүл уг этгээдтэй холбогдох этгээдийн хамааралгүй байх	Нөлөө бүхий хувьцаа эзэмшигчдийн баталгаа
7	Сүүлийн таван жилийн дотор тухайн банкинд ажиллаж байгаагүй байх	Банкны албан бичиг
8	Банкны үйл ажиллагааны үр дүнгээс хамаарч урамшуулал авдаггүй байх	
9	Тухайн банкинд төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнээр наймаас дээш жилээр ажиллаагүй байх	Банкны албан бичиг, мөн өөрөө баталсан бичиг
10	Банкны тухай хуулийн 3.1.12-т заасан банкны хувь нийлүүлэгч, томоохон харилцагч, эсхүл түүний эрх бүхий албан тушаалтан бус байх	Банкны албан бичиг, мөн өөрөө баталсан бичиг

